

# **СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2014 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

## **Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

### **1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 09 дүгээр сард 1 удаа хуралдаж, 6 асуудал хэлэлцэн 4 тогтоол баталлаа. Үүнд:

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2010-2014 оны төлөвлөгөөний биелэлт, 2014-2018 оны төлөвлөгөөний төсөл

Сэлэнгэ аймагт Уул уурхайн талаар баримтлах бодлогын тухай

2014 онд улс, аймгийн хөрөнгө оруулалт, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын ажил арга хэмжээний хэрэгжилтийн тухай мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан сонгон шалгаруулах комисс нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус иргэний зөвлөлд нэрээ дэвшүүлсэн иргэдийн материалуудтай танилцаад шаардлага хангасан 5 иргэний товч намтарыг цахим хуудас болон олон нийтийн самбар бусад хэлбэрээр иргэдэд ил тод байрлуулж, санал авах ажлыг зохион байгуулахаар шийдвэрлэлээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга түүний ажлын албаны ажилтнуудын дунд зохион байгуулагддаг уламжлалт туршлага солилцох уулзалт зөвлөгөөнийг Түшиг суманд амжилттай зохион байгууллаа.

Хяналтын тухай хуулийн төсөл түүнийг даган өөрчлөгдөж буй бусад хуулиудын өөрчлөлтүүдийн төслийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх ахмад зөвлөхүүдийн багаар хэлэлцүүлэн багийн гишүүдээс гаргасан саналыг нэгтгэж, уламжлахаар тогтлоо.

Мандал сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй Христийн шашны “Ариун үг” баптист сүмийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг 2 жилийн хугацаагаар сунгалаа.

Монголын нутгийн удирдлагын холбоо үүсч хөгжсөний 20 жилийн ойн үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагыг төлөөлж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тэргүүтэй нийт 8 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо.

### **2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн Засаг даргын Тамгын газраас Сайхан суманд “Төсвийн ил тод байдал” сэдэвт сумдын Төрийн сангийн төлөөлөгч, болон мэргэжилтнүүдийн үзүүлэх сургалтыг 2014 оны 09-р сарын 19-20-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Сумдын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор 2014 онд Баруунбүрэн, Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Ерөө сумдын “Соёл-эдийн засгийн өдрүүд”-ийг зохион байгуулахаар төлөвлөж, тайлант сард Цагааннуур, Түшиг, Ерөө сумдын соёл эдийн засгийн өдрүүдийг тэмдэглэлээ.

Тайлант сард аймгийн Хууль сахиулах байгууллагуудын “Нээлттэй өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулж аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэс, сум дундын 20 дугаар Шүүх, аймгийн Прокурорын газар, аймаг дахь Хууль зүйн туслалцааны төв, Тахарын алба, Өмгөөлөл, нотариатчдын салбар зөвлөлүүд оролцож иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө үзүүлж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, сум дундын 20 дугаар Шүүх, Прокурорын газар, орон

нутгийн Миний Монгол телевизтэй хамтран иргэдээ сонсьё шууд нэвтрүүлэг зохион байгуулж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсээс Сум дундын 20 дугаар Шүүхтэй хамтран “Нээлттэй Шүүх өдөрлөг”-ийг Сүхбаатар суманд зохион байгууллаа.

ОХУ-ын Буриад улсын ерөнхийлөгч Наговицын Вячаслав Владимирович тэргүүтэй төлөөлөгчид тус аймагт 2014 оны 09-р сарын 02-ны өдөр айлчлан, Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн үйл ажиллагаатай танилцаж, аймгийн Засаг даргатай ажил хэргийн уулзалт зохион байгууллаа. Тус уулзалтаар

-Буриад улсад мах гаргах

-Ахмад, Хүүхэд залуучуудыг сувилал зусланд харилцан амрах болон, бусад төрлийн нийгмийн асуудал

-Буриад улсаас мод оруулж ирэх гэсэн 3 чиглэлийн асуудал дээр тохиролцоонд хүрсэн.

Мал аж ахуй үйлдвэрлэл эрхлэгч иргэдийн идэвхийг өрнүүлэх, шилмэл омгийн мал амьтныг худалдах, худалдан авах, мэдээлэл авах, туршлага солилцох боломжийг олгох зорилгоор “Шилмэл мал-2014” үзэсгэлэн худалдааг Мандал суманд зохион байгуулж, Баянгол, Ерөө, Орхон, Баруунбүрэн, Жавхлант, Цагааннуур, Сайхан, Түшиг, Хушаат, Хүдэр, Мандал сумдаас нийт шилмэл омгийн 50 гаруй мал оролцлоо. Тус үзэсгэлэнгийн үеэр жороо морины уралдаан зохион байгуулж, “Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн”-ий үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд сурталчлах зорилгоор үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.

Аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарын гурвалсан гэрээний дагуу 2014 оны 09-р сарын 17-19-ны өдрүүдэд Сүхбаатар сумын Номтхан, Хаданхүй, Зөвлөх баг, Эмнэх баг өрхийн эрүүл мэндийн төвүүд, Мандал сумын Баянбаг, БАТУ, Ачитбаг өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хяналт, үнэлгээ хийж дууслаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авах 70361111 утсанд тайлант сард нийт 25 иргэн хандсанаас 11 иргэний өргөдөл гомдлыг шийдвэрлэж, 6 нь шийдвэрлэх шатандаа байна. 8 иргэн нь төрийн байгууллагын үйл ажиллагаа болон, амьдарч буй сум, орон нутгийнхаа талаар өөрийн саналыг илэрхийлсэн болно. Ирж буй өргөдлийн ихэнх хувь нь хүйтний улирал эхэлж байгаатай холбогдуулан халаалт өгөх хугацааг наашлуулах талаар хандсан байна.

### **3.ТҮЦ машины мэдээлэл:**

2013 оны 11 дүгээр сарын 18-нд Сэлэнгэ аймагт анх ТҮЦ машиныг суурьлуулж, иргэдэд үйлчилгээ үзүүлж эхэлсэн. Тус хугацаанд ТҮЦ машинаар иргэний үнэмлэхний лавлагаа 1126, Оршин суугаа хаягийн тодорхойлолт 936, гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа 110 нийт 2241 иргэн үйлчлүүлсэн байна.

### **Бусад ажлын талаар:**

#### **1.Онцгой байдлын газар:**

“Боловсролын байгууллага”-д Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм норм стандартын хэрэгжилтийг шалгах төлөвлөгөөт удирдамжийн дагуу Сүхбаатар сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ерөнхий боловсролын 1-р сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байрнууд мөн ерөнхий боловсролын сургуулийн 2, 3, 4, 5, 6 дугаар сургуулиудын байр, Төмөр замын Бүжинхэн цэцэрлэгийн 1, 2, 3, 4 дүгээр байрууд, 3, 4, 7-р цэцэрлэг, Одхон 1 дүгээр цэцэрлэг, 2 дугаар цэцэрлэг, Эрдэмийн чуулган цэцэрлэг зэрэг нийт 14 аж ахуйн нэгж, байгууллага биелэлтийн шалгалтанд хамрагдаж урьд өгөгдсөн гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн

заавал биелүүлэх албан шаардлага, мэдэгдэлд 256 зөрчил илэрч, гүйцэтгэлийн шалгалтын явцад 123 зөрчил дутагдал арилж нийт зөрчлийн 65 хувь ариллалаа.

“Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц, шингэрүүлсэн хийн түлшний станц”-уудад Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм норм стандартын хэрэгжилтийг шалгах төлөвлөгөөт шалгалтын хүрээнд Сүхбаатар, Мандал, Сайхан, Баянгол, Алтанбулаг, Зүүнбүрэн, Шаамар сумдад үйл ажиллагаа явуулж буй 24 шатахуун түгээх станц, 4 шатахууны агуулах, объектод гамшгаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 254 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 21, мэдэгдэл 7, хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн шаардлагыг хэрэгжүүлээгүй 1 аж ахуйн нэгж, байгууллагыг 250.000 төгрөгөөр 3 албан тушаалтаныг 130.000 төгрөгөөр торгож захиргааны арга хэмжээ ногдууллаа.

“Эрчим хүч үйлдвэрлэгч, түгээгч байгууллагуудад гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм, стандартын хэрэгжилтийг шалгах удирдамж”-ийн хүрээнд 10 объект, аж ахуйн нэгж, байгууллагуудад биелэлтийн шалгалтыг зохион байгуулж урьд өгөгдсөн гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлагад 102 зөрчил илэрч, гүйцэтгэлийн шалгалтын явцад 83 зөрчил дутагдал арилж, нийт зөрчлийн 81.3 хувь нь ариллалаа.

“Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, эрхлэж буй аж ахуйн нэгж байгууллагуудад” гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль дүрэм стандартын хэрэгжилтийг” шалгах төлөвлөгөөт шалгалтаар шалгалтанд хамрагдсан 36 байгууллагуудад гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийж, урьд өгөгдсөн гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлагад 139 зөрчил илэрч, гүйцэтгэлийн шалгалтын явцад 121 зөрчил дутагдал арилж, 87 хувь биелж, зөрчил дутагдалыг бүрэн арилгуулахаар 5 аж ахуйн нэгжид гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн мэдэгдэл хүргүүлээ.

## **2.Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:**

Намрын ургац хураалтанд ашиглагдах автопүү баталгаажуулалтаар Баянгол, Мандал, Түшиг, Цагааннуур, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн, Сант, Хушаат, Зүүнбүрэн, Шаамар, Ерөө сумдад ажиллан, 40 авто пүүг баталгаажуулж, улсын ургацын комисст мэдээг тухай бүр өгч ажиллалаа.

Аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтсээс Мандал сумын үсчин гоо сайхны үйлчилгээ эрхлэгч нарт “Гоёлын гоо заслын үйлчилгээнд тавих шаардлага MNS 5567:2006”, “Үс засах үйлчилгээ MNS 5160:2002” стандартын талаар сургалт зохион байгууллаа.

Орхонтуул, Орхон, Сант, Хушаат, Жавхлант, Орхонтуул, Баруунбүрэн, Баянгол, Мандал, Сүхбаатар сум, Рашаант, Номгон тосгонд худалдаа үйлчилгээ эрхлэж буй 45 худалдаа, нийтийн хоол, үсчин, гоо сайхны үйлчилгээний газруудад тохирлын үнэлгээ хийлээ.

Сүхбаатар, Шаамар, Цагааннуур, Сайхан сумын 12 аж ахуйн нэгж, иргэний 6 нэрийн 26 бүтээгдэхүүнийг сайн дурын баталгаажуулалтанд хамруулж, итгэмжлэгдсэн лабораторийн сорилт, шинжилгээний дүнг үндэслэн шинжээчийн дүгнэлт гаргалаа.

“Редхилл Монголия” ХХК-ийн ОХУ-д экспортлож буй 1999.68 тн чулуун нүүрсний 8 удаагийн тээвэрлэлтэнд тохирлын баталгаа гаргаж, гэрчилгээ олголоо.

Стандартын салбар сангаас 7 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу 7 нэрийн 12 стандартаар хангаж, 3 нэрийн 3 стандартаар үйлчилж, арга зүйн зөвөлгөө өглөө.

Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийн тооцоонд ашиглагдаж буй 1 фазын 1000 ширхэг цахилгаан тоолуурыг ээлжит баталгаажуулалтанд хамрууллаа.

Мандал сумын “СББ” ХХК-ийн сорилтын лабораторийн 17 жин, хэмжүүр, 6 мерник, 10 шилэн хэмжүүрийг шалгалт тохируулгад, үйлдвэрлэлийн 8 жинг ээлжит баталгаажуулалтанд хамрууллаа.

### **3.Мэргэжлийн хяналтын газар:**

Мэргэжлийн хяналтын газар нь 2014 онд 3 зорилт 37 арга хэмжээний 119 шалгуур үзүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн хэмжээнд 63 улсын байцаагч хэрэгжилтийг хангуулж, төрийн хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэж байна. Их эрсдэлтэй гэж үнэлэгдсэн 377 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт, 277 объектод зөвлөн туслах үйлчилгээ, 31 чиглэлээр тандалт судалгаа, 14 чиглэлээр хяналт шинжилгээний ажлууд хийж ажиллахаас 3 дугаар улирлын байдлаар удирдамжийн 352 объектод төлөвлөгөөт, 583 төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн 305 хяналт шалгалтыг хийж, салбарын 22, байгууллагын 174 сургалт зохион байгуулж, 299 объектод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

Улсын байцаагчаас 273 удаагийн мэдэгдэх хуудас, 301 хяналт шалгалтын хуудас, 285 хяналт шалгалтын тэмдэглэл, 189 албан шаардлага, 98 акт, 269 дүгнэлт гаргаад байна.

Хяналт шалгалтаар 1167 зөрчил илрүүлж, 958 зөрчлийг бүрэн арилгуулж, 165055.0 төгрөгийн нөхөн төлбөр, 80567.0 төгрөгийн торгууль ногдуулсаны 77467.0 төгрөгийн торгуулийг бүрэн барагдууллаа.

### **Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

#### **1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

8-р сарын 31-ний байдлаар

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	10706737.10	9216301.80	86.1
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	8829340.40	7570912.50	85.7
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	50765973.5	42461663.9	83.6
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлагын дүн	14833641.1	11411770.4	76.9
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	4013570.7	2179775.5	54.3
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	10398280.00	4471733.70	43.0
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	2986981.60	2986981.60	100.0
5	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	4739451.9	4739451.9	100.0
7	Засаг даргын нөөц	453571.5	367072.9	80.9

2014 оны төсвийн гүйцэтгэлийн 8 сарын мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 86.1 хувь, улсаас авах санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 54.3 хувь, салбарын байгууллагуудын тусгай зориулалтын шилжүүлэг 100.0 хувь тус тус биелэгдсэн байна. Төсвийн зарлагын гүйцэтгэл 83.6 хувийн биелэлттэй байна. Аймгаас олгох сумдын санхүүгийн дэмжлэг 100 хувь, Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 80.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

## 2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

№	Барааны нэр, төрөл	Хэмжих нэгж	Үнэ, ханш /төгрөгөөр/	
			2013 оны 8-р сар	2014 оны 9-р сар
Нэг.Талх, гурил, будаа				
1	Гурил /1-гурил/	1 кг	1100	1200
2	Талх /орон нутгийн/ том, жижиг	ш	900, 2000	1000, 2200
3	Нарийн боов	1 кг	1900-2500	1900-2500
4	Элсэн чихэр	1 кг	1800-2000	1800-2100
5	Цагаан будаа	1 кг	2200	2200-2400
Хоёр.Мах, махан бүтээгдэхүүн				
6	Хонины мах	1 кг	7000	7000
7	Үхрийн мах	1 кг	8000	8000
8	Адууны мах	1 кг	6500	6500
9	Ямааны мах	1 кг	6000	6000
10	Дотор мах цувдай	1 кг	4000	4000
11	Хиам, чанасан	1 кг	9000	9000
12	Гахайн мах	1кг	6000	6000
Гурав.Сүүн бүтээгдэхүүн				
12	Сүү /задгай/	1л	700	800
13	Сүү /савласан/	1л	2500	2500
14	Тараг /задгай/	1л	800	900
15	Хорхой ааруул	1 кг	8500	8500
16	Айраг	1л	2000	-
17	Хуурай сүү /орос/	1 кг	4000	4000
18	Өндөг	ш	350-400	350
Дөрөв. Бүх төрлийн өөх тос				
19	Ургамлын тос	1 кг	2900-3300	2900-3300
20	Өөхөн тос	1 кг	1500	1500
21	Шар тос	1 кг	8000	8000
22	Масло /задгай/	1 кг	3200	3200
Тав.Хүнсний ногоо				
23	Төмс	1 кг	800	800
24	Лууван	1 кг	800	1000
25	Манжин	1 кг	800	800
26	Байцаа	1 кг	500	800
27	Сонгино	1 кг	1500	1000-1500
28	Өргөст хэмх	1 кг	700	-
29	Тарвас /Монгол/	1 кг	-	-
30	Өргөст хэмх /даршилсан/	ш	3500	3500
31	Алаг салат /даршилсан/	ш	1900-2500	1900-2500
Зургаа.Тээвэр шатахуун				
32	Бензин А-80	1 л	1590	1590
33	Бензин А-92	1 л	1700	1690
34	Дизель түлш	1 л	1830	1830

### **Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

Тайлант сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас гэмт хэрэг, захиргааны зөрчлийн шинжтэй 132 гомдол мэдээлэл хүлээн авч эрүүгийн 21 хэрэгт дугаар авч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явууллаа. Торгуулийн хуудсаар зөрчил гаргасан 362 иргэнийг 1.383.000 төгрөгөөр, шийтгэврээр зөрчил гаргасан 102 иргэнийг 1.865.000 төгрөгөөр торгож, захиргааны журмаар 10 иргэнийг баривчлуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 20 жолоочийн эрхийг хасч, согтууруулах ундаа хэрэглэн биеэ удирдан авч явах чадваргүй байсан, зөрчил гаргасан зэрэг 31 иргэнийг эмчийн хяналтанд саатуулж ажиллалаа.

#### **1. Архивын талаар:**

Төрийн архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлэх зорилгоор шинээр хөмрөг үүсгэх Мэргэжлийн хяналтын газар, 12 жилийн 1-р сургууль, аймгийн Нэгдсэн музей, Нийтийн номын сан зэрэг нийт 4 байгууллагын Төрийн архивт байнга хадгалах баримтыг цаасан буюу цахим хэлбэрээр хүлээн авах ажлыг зохион байгуулж байна.

“Ургамлын далай” ХХК-ийн Ерөө сумын Нарлаг цэцэрлэгийн гадна талбайн тоглоом, “Мандал сүлжээ” ХХК-ийн Зүүнхараа хотын гудамж замын гэрэлтүүлэг болон шинэчлэн сайжруулах зураг төслийн баримт бичиг, “Нүнжиг” ХХК-ийн Цагааннуур сумын сургуулийн засварын ажил, “Хүнх сэрвэн” ХХК-ийн Сүхбаатар сумын 5-р сургуулийн заалны засвар, Баянгол сумын сургуулийн гал тогооны засварын ажлын зураг төслийн баримт бичгийг хүлээн авч бүртгэл, акт үйлдэн хөмрөгт байрлууллаа.

Баримтанд нягтлан шалгалтын ажлыг Мод боловсруулах комбинатын 1961-1991 оны 80 хадгаламжийн нэгж, Хүдэр тэжээлийн аж ахуйн 1971-1992 оны 110 хадгаламжийн нэгж, Тээвэр авто замын удирдах газрын 1962-1998 оны 44 хадгаламжийн нэгжид иж бүрэн нягтлан шалгалтын ажлыг хийж, хадгалах хугацаа дууссан болон мэдээлэл, лавлагааны ач холбогдолгүй болсон, эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийх шаардлагатай, цахим хэлбэрт шилжүүлэх баримтуудыг олж илрүүлэх, тэдгээрт тус бүрд нь жагсаалт үйлдэх, тус хөмрөгийн дансны хадгаламжийн нэгжийн бүртгэлийн хэсгийг шинэчлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Төрийн архивын AMS программд Ерөө сангийн аж ахуйн хөмрөгийн 42 хадгаламжийн нэгжийн 10075 хуудасны мэдээллийн агуулгыг уншиж 23689 заалт, 38322 хүний нэр, 1811 байгууллагын нэр, 791 газар зүйн нэрийг шивж орууллаа. Мөн Ерөө сангийн аж ахуйн хөмрөгийн 37 хадгаламжийн нэгжийн 6623 хуудсыг серверт задалж холболт хийлээ.

Баримтын мастер хувиас photoshop программ ашиглан Ерөө сангийн аж ахуйн хөмрөгийн 35 хадгаламжийн нэгжийн 6298 хуудсыг ашиглалтын хувь үүсгэлээ.

Иргэд албан байгууллагын гаргасан хүсэлтийн дагуу архивын хуулбар 63, цалингийн тодорхойлолт 2, магадлагаа 22, тодорхойлолт 20 гаргаж үйлчиллээ.

### **Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

#### **1. Эрүүл мэнд, хүүхэд залуучуудын талаар:**

“Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд гэр бүлийн цагаар “Нандин-Эрдэнэ” цувралын “Завгүй аав” нэвтрүүлгийг Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургуулийн 12 жилийн 1 дүгээр сургуулийн 5 дугаар ангийн сурагч түүний эцэг эхийг оролцуулан Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, орон нутгийн Миний Монгол кабелийн телевизтэй хамтран зохион байгууллаа.

Хүүхдийн төлөө Үндэсний газраас хэрэгжүүлж буй “Миний гэр бүл” хөгжлийн хөтөлбөрийг Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3, 5, 6 дугаар сургуулийн зорилтот бүлгийн 50 хүүхэд тэдний гэр бүлийг хамруулан 5 чиглэлээр арга зүйн

зөвлөгөө өгч, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж байна.

“Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд “Гэр бүлийн хөгжилд хамтдаа” сургалтыг аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн газар хамтран нийт сумын нийгмийн ажилтнуудад сургалт зохион байгууллаа.

Өдөр тутам эрүүл мэндийн байгууллагуудаас хэвтэн эмчлүүлэгчдийн мэдээг авснаас өдөрт дунджаар 305 өвчтөн хэвтэн эмчлүүлж, 31 жирэмсэн эх эмнэлгийн тусламж үйлчилгээ авч, 0-5 насны 42 хүүхэд, 6 хүнд анхаарал татсан хүн хэвтэн эмчлүүлж байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал Ч.Бат-Эрдэнээр ахлуулсан ажлын хэсэг “Эрүүл мэндийн довтолгоо”-ны үйл ажиллагаа, хэрэгжилт, 2012-2014 оны 9 сар хүртлэх 0-1 насны хүүхдийн эндэгдэлд тандалт судалгаа хийлээ.

Эрүүл мэндийн яамнаас 2014 оны “Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбоотойгоор аймгийн Эрүүл мэндийн газраас Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны оюутнуудад сургалт зохион байгууллаа.

Аймгийн Эрүүл мэндийн газраас Сүхбаатар сум болон хөдөө орон нутгийн нийт 4 дотуур байрны сурагчдад “Оюутны эрүүл мэндийг дэмжих сар”-ын хүрээнд эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрсдэлт зан үйлээс өөрийгөө хамгаалах чадварт суралцуулах зорилгоор, зорилтод сэдвүүдийн хүрээнд сургалт зохион байгууллаа. Тус сургалтанд нийт 200 гаруй оюутан сурагчдыг хамрууллаа.

“Хүүхдийг эхийн сүүгээр дагнан хооллох дэлхийн өдөр”-ийг угтан аймгийн Эрүүл мэндийн газар, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран Сүхбаатар сумын 30 хөхүүл эх, 21 жирэмсэн ээжүүдэд “Ангир уургийн ач тус”, “Хүүхдийг эхийн сүүгээр хооллохын ач холбогдол”, “Хөхний сүүний ач холбогдол”, “Хүүхдээ хөхөөр хоолоё”, “Хүүхдийн нэмэгдэл хоол”, “Хөхөө хэрхэн арчлах, хэрхэн шалгах вэ?”, “Үе тэнгийн зөвлөгч юу хийдэг вэ?” зэрэг сэдвүүдээр сургалт хийж харилцан туршлага судлууллаа.

## **2. Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:**

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 3074 иргэнд 2749437.8 мянган төгрөг, нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 1320 иргэнд 644495.3 мянган төгрөг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 3052 иргэнд 193788.1 мянган төгрөг, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжинд 890 иргэнд 342248.4 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 474 иргэнд 79607.4 мянган төгрөгийн тусламж хөнгөлөлт үйлчилгээг, эхийн алдар одонтой 8534 эхэд 1162620.0 мянган төгрөгийн тусламжийг олголоо.

Жирэмсэн, хөхүүл нярай хүүхэдтэй 2982 эхэд 898237.6 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 239 иргэнд 43743.0 мянган төгрөгийг зарцууллаа.

Алдар цолтой ахмадуудад үзүүлэх хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд 70 иргэнд 62470.0 мянган төгрөгийг тус тус олголоо.

## **3. Боловсролын талаар:**

Friends Korea залуусын дунд хугацааны сайн дурын багийнхан аймгийн Боловсролын газартай хамтран 2014 оны 08-р сарын 13-ны өдрөөс эхлэн 6 сарын хугацаатайгаар ажиллаж байна. Сайн дурын багийнхан ерөнхий боловсролын сургуулийг түшиглэн хичээлээс гадуурх хүүхдийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Аймгийн Боловсролын газраас Насан туршийн боловсролын багш нарт “Гэгээрэл хөгжлийн төвийн үйл ажиллагааны чиглэл, цаашдын зорилт” сэдэвт сургалтыг 2014 оны 09-р сарын 12, 13-ний өдрүүдэд Алтанбулаг сумын Гэгээрэл төвд зохион байгууллаа.

Сурагчдын дүрэмт хувцасны борлуулалтыг Дарханы “Шүтэн-уул” ХХК-тай хамтран Сүхбаатар, Мандал, Хөтөл бүсүүдэд зохион байгуулж, 2014 оны 09-р сарын 17-ны дотор хангалт хэрхэн байгаа талаарх судалгааг сургууль бүрээр гарган БШУЯ-нд хүргүүллээ. Дүрэмт хувцасны хангалтын байдал 83.5 хувьтай байгаа өнгөрсөн жилийнхээс 6.1 хувиар нэмэгдсэн дүнтэй байна.

Аймгийн Боловсролын газар, Соёл, спорт, аялал жуулчлалын газар хамтран “Номын баяр” арга хэмжээг 2014 оны 09-р сарын 24-ний өдөр зохион байгууллаа.

#### **4. Нийгмийн даатгалын үйлчилгээний талаар:**

2014 оны 09 дүгээр сард Нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын сангуудад 16637029.5 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгээс 16674011.2 сая төгрөг хурааж, төлөвлөгөөний биелэлт 100.2 хувьтай байна. Аймгийн хэмжээнд 19 нэгжээс 10 сум нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 4-11.2 хувиар давуулан биелүүлж, 7 сум 0.1-29.0 хувиар төлөвлөгөөг тасаллаа.

Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын сангаас 13717 тэтгэвэр авагчдад 25.3 тэр бум төгрөгийн тэтгэвэр олголоо.

Тэтгэмжийн даатгалын сангаас 4129 даатгуулагчдын хөдөлмөрийн чадвар түр алдалт, жирэмсэн амаржсан, оршуулгын зардалд 1237,6 сая төгрөг олголоо.

Эрүүл мэндийн даатгалын сангаас нийт 9 эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 30 эмийн сангаар үйлчлүүлсэн 45551 даатгуулагчийн эмийн үнийн хөнгөлөлт, эмчилгээний зардалд 2037717.7 сая төгрөг шилжүүлээд байна.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 267 даатгуулагчид 312.1 сая төгрөгийн тэтгэмж олголоо.

Нийгмийн даатгалын Ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газраас 2014 оны 09-р сарын 08-23-ны өдрүүдэд нийт сумдын 2012 оны 4-р улирлаас 2014 оны 2-р улирлыг дуусталх хугацаанд шинээр тогтоогдсон тэтгэврийн хувийн хэргүүдэд, Хөтөл, Мандал Сүхбаатар сумдын нийт хувийн хэрэгт хяналт шалгалт хийлээ.

#### **5. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:**

2014 оны 08 сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 873 хүн байсан бол шинээр 143 хүн бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 75 ажлын байранд 61 хүнийг ажилд зуулчилж, идэвхгүйн улмаас 120 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 835 боллоо.

Мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөрийн 2-р ээлжээр суралцагчдаас төгсөлтийн шалгалт авч 16 иргэнийг ажлын байранд зуучлаад байна. Баянгол сумын “Мен-теч” ХХК дээр ур чадварын шалгалтыг авч 16 иргэнийг ажлын байранд зуучлан ажиллалаа.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Хөдөлмөр сургалтын төвтэй хамтран Хүдэр, Ерөө сум, Бугант тосгонд “Нийгмийн түншлэл, иргэдийн амжиргаа” сэдэвт уулзалт өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгөөр нийт 169 ажил олгогч болон иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч, гарын авлага тараан ажиллалаа.

Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг сумдын малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 5 өрхийн хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт, шинжилгээ хийж, сумдын мэргэжилтнүүд болон хөтөлбөрт хамрагдсан иргэдэд өрхийн хөгжлийн төлөвлөгөө бичих болон арга зүйн зөвлөгөө өглөө.

Сайхан, Орхон сум, Номгон тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 9, 12-р ангийн 7 бүлгийн 144 сурагчдад “Мэргэжил бүхэн сайхан” сургалтыг зохион байгууллаа.

#### **Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:**

Аймгийн хэмжээнд 174.0 мянган га-д тариалалт хийснээс одоогоор үр тариа 178.3 мянган га-аас 108.9 мянган тн буюу 15.2 цн, тэжээлийн ургамал 422 га-аас



3.3 мянган тн буюу 71.8 цн, тосны ургамал 9.8 мянган га-аас 6.9 мянган тн буюу 7.1 цн, төмс 2.2 мянган га-аас 34.4 мянган тн буюу 152 цн, хүнсний ногоо 1.6 мянган га-аас 23.1 мянган тн буюу 135 цн хураан авч хураалт 50.9-77.5 хувьтай явагдаж байна.

Алтанбулаг, Цагааннуур, Сайхан, Баруунбүрэн, Орхонтуул, Баянгол, Хушаат зэрэг сумдын 16 аж ахуйн нэгжийн 3.3 мянган га-д улаанбуудай сортын хянан баталгаа хийснээс 3.0 мянган га нь улаан буудай үрийн чанарт тэнцэж, Орхонтуул сумын 2 аж ахуйн нэгжийн 369 га нь улаанбуудай тарих үрийн стандартад тэнцсэнгүй.

НҮБ-ын Хөдөө аж ахуйн байгууллага, ургамал хамгааллын хүрээлэнтэй хамтран “Хүлэмжийн аж ахуйн ургамал хамгаалах цогцолбор аргын сургагч багш бэлтгэх”, “Үр тарианы ургамал хамгаалах цогцолбор аргын сургагч багш бэлтгэх” сургалтанд Мандал, Сүхбаатар, Жавхлант, Сант, Цагааннуур сумдын 5 агрономич, 2 аж ахуйн нэгжийг хамруулж, дээрхи чиглэлээр 5 бүсэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх мэргэжилтэн бэлтгэлээ.

“Алтан намар-2014” шинэ ургацын төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний үзэсгэлэн худалдаанд Шаамар, Сайхан, Зүүнбүрэн, Хушаат, Мандал, Алтанбулаг, Баянгол, Сант, Жавхлант, Сүхбаатар сумдын 60 гаруй ногоочид 2500 тн төмс, 3000 тн хүнсний ногоо, 5000 ширхэг даршилсан ногоо, 1 тн зөгийн бал борлуулж, 1 тэр бум төгрөгийн борлуулалт хийж, 7 хоногийн турш нийслэлийн хүн амыг эрүүл, экологийн цэвэр төмс, хүнсний ногоогоор хангалаа.

“Эрүүл хүнс-2014” хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаанд Орхон, Шаамар, Сүхбаатар сумдын 2 аж ахуйн нэгж, 6 хүнс үйлдвэрлэгч оролцож, 2000 ширхэг утсан загас, 1500 ширхэг хмелийн талх, 5000 ширхэг зөгийн балаар баяжуулсан бүтээгдэхүүн борлуулж, 30 сая төгрөгийн борлуулалт хийлээ.

Үйлдвэр, хөдөө аж ахуй яамтай хамтран Баянзүрх дүүргийн “16-р хороолол”, 1000 нэрийн барааны дэлгүүрийн урд талбайд, “Скай”, “Дүнжингарав”, “Шөнийн захын замын эсрэг тал”-д, Хан-Уул дүүргийн “Хоум плаз” ХХК, 19-р хороолол, Чингэлтэй дүүргийн “Барилгачдын талбай”, 7 буудлын зам дагуу, Сүхбаатар дүүргийн “Гурван гал” зэрэг газруудад Алтанбулаг, Мандал, Орхон, Сант, Сүхбаатар, Цагааннуур, Түшиг, Баруунбүрэн, Зүүнбүрэн, Шаамар сумдын 130 ногоочид 2000 тн төмс, 3200.6 хүнсний ногоо, 3.2 тн зөгийн бал, 15600 ширхэг даршилсан ногоог өнөөдрийн байдлаар борлуулж байна.

### **Зургаа. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:**

#### **1. Газрын харилцааны талаар:**

Тайлант сард аймгийн Засаг даргын 4 удаагийн захирамжаар өмнө нь гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа газар өмчилж авсан иргэдийн хамтран өмчлөгч хасуулах хэлцлийг үндэслэн нийт 4 иргэний газар өмчлөх эрхийг хэвээр үлдээж 11 иргэний газар өмчлөх эрхийг нээлээ.

Сүхбаатар сумаас одоо эзэмшиж буй газраа өмчилж авах хүсэлт гаргасан 21 иргэнд 2.3 га газрыг өмчлүүлэхээр Засаг даргын захирамжаар нэг удаа үнэ төлбөргүйгээр өмчлүүлэх шийдвэр гаргууллаа.

Газар өмчлөх эрхээ тухайн суманд хэрэгжүүлсэн эсэх лавлагааг нийт 50 иргэнд Алтанбулаг, Сайхан, Шаамар, Хүдэр сум болон, Нийслэлийн Баянзүрх, Баянгол дүүрэгт тус тус хүргүүллээ.

“Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбилцлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбилцол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарт Жавхлант, Ерөө, Хүдэр, Зүүнбүрэн, Шаамар, Цагааннуур, Орхонтуул сумд, Бугант тосгонд хувийн хэргийн бүрдүүлэлтийг хийж ажиллалаа.

Газар өмчилж, эзэмшиж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн байгууллагаар хэмжилт, боловсруулалт хийлгэсэн 28 кадастрын зургийг хүлээн авч аймгийн газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж баталгаажууллаа.

Сэлэнгийн ай сав газрын хэмжээнд Монгол улсын иргэнд өмчлүүлэх болон аж ахуйн эргэлтэд оруулах боломжтой газрын нөөц, хэмжээ, байршлийг тодорхойлж, сумын 2014, 2015 оны газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгуулах, түүний газар зохион байгуулалт болон кадастрын баталгаажуулалтыг хийх замаар газрыг төлөвлөгөөтэйгээр эдийн засгийн эргэлтэнд оруулах зорилгоор Хүдэр, Ерөө сум Бугант тосгоны нийт 15 аж ахуй нэгжийн үйл ажиллагаатай танилцаж, газрыг хэрхэн эргэлтэнд оруулах, зөв зохистой ашиглах талаар зөвлөгөө өгч, тэдний саналыг хүлээн авлаа.

## **2. Барилга хот байгуулалтын чиглэлээр:**

“Сумын шинэчлэл төсөл”-өөр Цагааннуур сумын төвд хийгдэж буй иж бүрэн инженерийн шугам сүлжээ, халаалтын зуух, цэвэр усны эх үүсвэрийн шугам хоолойн угсралтын ажилд явцын техник хяналтыг 2 удаа хийлээ.

Баруунбүрэн суманд баригдаж дууссан “Спорт заал”- ны барилгыг улсын комиссоор хүлээж авлаа.

Сүхбаатар сумын 1-р сургуулийн барилгын их засварын ажил дууссан тул улсын комисс ажиллаж дутуу буюу чанаргүй хийгдсэн ажлуудыг дахин засварлаж гүйцээх үүрэг даалгавар өгч биелэлтийг хангасны дараа хүлээн авахаар шийдвэрлэлээ.

Орхонтуул сумын Рашаант тосгонд баригдаж буй “Соёлын төв, захирагчийн албаны контор”-ын барилга угсралтын ажилд явцын хяналт хийлээ.

Мандал сумын Хэрх тосгоны 75 хүүхдийн цэцэрлэгийн барилга, 100 ортой цэцэрлэг, Нархан цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга, Баянгол сумын Хүүхэд хөгжлийн төвийн барилгад захиалагчийн хяналт хийлээ.

## **Долоо. Байгаль орчны чиглэлээр**

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх “Элсний нүүлт, цөлжилтөөс сэргийлэх зорилгоор Орхон, Жавхлант, Баянгол суманд хамгаалалтын ногоон зурвас байгуулах” харьцуулалтын аргын тендер шалгаруулалтыг зохион байгуулж, “Бугант минж” ХХК, “Жаврай” ХХК, “Цогтманлай” ХХК, “Батдэм” ББН, “Баянгол” нөхөрлөл, Жавхлант сумын иргэн Д.Цэвэгжав, Баруунбүрэн сумын иргэн н.Мөнх-Эрдэнэ, Сүхбаатар сумын иргэн н.Баяраа нарт тендерийн урилга хүргүүлж, ажлын хэсгийн бүрэлдэхүүн хамгаалалтын ногоон зурвас байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгарууллаа.

“Дашваанжил ХХК”, “Сэлэнгэ Ундрэм” ХХК, “Бүтээлийн нуруу” ХХК-д байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг хийлээ.

Хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох зорилгоор Шаамар сумын 4-н замын хяналтын постод Алтанбулаг, Шаамар, Ерөө, Жавхлант зэрэг сумдын байгаль хамгаалагч нар, Байгаль орчны газартай хамтран хяналт тавин ажиллаж байна.

Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын А/204 тоот тушаалаар Устгах шаардлагатай химийн хорт болон аюултай бодис, аюултай хог хаягдлын эх үүсвэрийн тооллогыг хийж байгаль орчин ногоон хөгжлийн яаманд хүргүүлээ. Тооллогоор аймгийн ерөнхий боловсролын нийт 14 сургууль химийн бодис ашиглаж байгаагаас, устгах шаардлагатай 304 төрлийн бодис, нэр төрөл тодорхойгүй 61 бодис, нийт 365 бодис сургуулийн химийн лабораторид хадгалагдаж байна. Устгах шаардлагатай химийн бодисын нийт хэмжээ ерөнхий боловсролын сургуульд 947.6 кг орчим байна. Мөн аж ахуйн нэгж,

байгууллагуудад хадгалагдаж байгаа устгах шаардлагатай бодисын нийт хэмжээ 25295.4 кг бодис тоологдлоо.

### **Найм.Тээвэр авто замын талаар:**

Аймгийн Тээвэр авто замын газраас намрын ургац хураалтын тээвэрлэлт, оюутан сурагчдын хичээл эхлэсэнтэй холбогдуулан орон нутаг, хот хоорондын ачаа зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулдаг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын авто тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон даац, зорчигч тээвэрлэлтийн норм, техникийн бүрэн бүтэн байдал зэрэгт “Авто тээврийн тухай хууль” болон холбогдох хууль, дүрэм, журам, стандартын шаардлагыг хэрхэн хэрэгжүүлж байгаа, Авто тээврийн хэрэгслийн техникийн улсын үзлэг оношлогоонд хамрагдсан эсэхэд авто тээврийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Ургац тээвэрлэлтийн” сарын аяны хүрээнд орон нутагт Дулаанхаан 4-н замын пост, Шарын голын гүүр, Сүхбаатар самбар, Шаамарын гүүр зэрэг газруудад авто тээврийн хяналт шалгалтыг шуурхай, үр дүнтэй зохион байгуулан ажиллалаа.

Сүхбаатар самбар, Шаамарын гүүр, Дулаанхаан 4-н замын постоор нэвтрэн өнгөрч буй тээврийн хэрэгслүүд болон хүнд даацын машин, механизмуудын техникийн бүрэн бүтэн байдал, тээврийн хэрэгслийн улсын үзлэг оношлогоонд хамрагдсан эсэх, зорчигчийн норм хэтрүүлэлт, ачаа болон хүнд даацын тээврийн хэрэгслүүдийн даацын хэтрүүлэлтийг явуулын пүү ашиглан шугам замын хяналт шалгалтыг явуулж, нийт 87 тээврийн хэрэгслийг хамруулж, 28 зөрчлийг илрүүлж, газар дээр нь арилгуулж, 59 зөрчилд “Авто тээврийн тухай хууль”-ийн 23.1.1, 23.1.4 дахь заалтуулыг үндэслэж захиргааны арга хэмжээ авч 1180.0 сая/төг-ийн торгууль шийтгэврийг оногдуулан барагдууллаа.

### **Найм.Сүм орон нутгийн талаар:**

#### **1.Алтанбулаг сум:**

Тус сумын нутаг дэвсгэрийн Цэнхэрийн булан, сумын төвийн Солдат толгойн урд хэсэг, Сэлэмтийн зүүн хэсгээр нийт 161 иргэнд 131.4 сая төгрөгийн үнэ бүхий 17.51 га газрыг гэр бүлийн хэрэгцээнд зориулж үнэ төлбөргүйгээр өмчлүүлээд байна.

Намрын ургац хураалтын ажил эхлээд үр тариа 50 хувь, төмс хүнсний ногооны хураалт 95 хувьтай явагдаж, хадлан тэжээлийн бэлтгэл одоогоор 7000 тн өвс бэлтгээд байна.

Тайлант сард аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Цэвэр ус, гүний худгийн шинэчлэл”-ийн ажлыг ажлын хэсэг томилон гүйцэтгэлд хяналт хийж хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авлаа. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Хондын чиглэлийн цахилгааны шинэчлэл”-ийн ажил, “Нийтийн биеийн тамирын талбайн цогцолбор” ажлын хэсэг томилон гүйцэтгэлд хяналт хийж хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авах хүсэлт тавьж хамтран ажиллаж байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, тус сумын Засаг даргын Тамгын газар хамтран хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг 2014 оны 09-р сарын 16-ний өдөр нийт 200 гаруй сурагчдыг хамруулан зохион байгууллаа.

#### **2.Баянгол сум:**

Тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2014 оны 09 сарын 03-ны өдөр ойн санг гэрээгээр эзэмшиж буй 4 нөхөрлөлийн үйл ажиллагаатай танилцан, 3 аж ахуйн нэгжийн уул уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг шалгаж, гарсан зөрчил дутагдлын талаар заавар, зөвлөгөө өглөө.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, хэлмэгдэгсдийн ар гэрийн судалгааг гаргаж, сумын удирдлагуудтай хамтран уулзалт ярилцлага зохион байгуулан, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад хичээл заалаа.

2014 оны 09 дүгээр сарын 19-22-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Улсын клиникийн нэгдсэн эмнэлэгийн нийт 35 эмч хүрэлцэн ирж тус сумын иргэдэд үзлэг, оношилгоо үнэ төлбөргүй хийж, үйлчилгээ үзүүлэн хамтран ажиллалаа.

Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын яамнаас 2014 оныг Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан “Хамтдаа бүтээе” аяны хүрээнд Дэлхийн зөн олон улсын байгууллагын эдийн засгийн хөтөлбөртэй хамтран залуу гэр бүлийг орон сууцжуулах зорилгоор 1 өрхөд 5.0 сая төгрөгийн материалын буцалтгүй тусламж үзүүлж мөн “Бороо сан”-аас 3.0-5.0 сая төгрөгийн зээлээр дэмжлэг үзүүлж, 5 өрхийг орон сууцтай болголоо.

### **3.Жавхлант сум:**

Тус сумын Засаг даргын 2014 оны А/63 тоот захирамжийн дагуу сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг өвөлжилтийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Тус сумын Бумбат, Моностой багуудын нийт 412 малчин болон мал бүхий иргэд өвөлжилтийн бэлтгэл хангаж өвс, тэжээл 6825 тн, хужир 35 тн бэлтгэлээ.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас худалдаа, үйлчилгээ, нийтийн хоолны салбарт эрүүл ахуй, үйлчилгээний стандарт шаардлагыг мөрдөн ажиллаж буй байдалд хяналт шалгалт хийж, холбогдох хууль тогтоомжийг сурталчилан гарсан зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг авлаа.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 5 өрхөд өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах өвс тэжээлийн нөөц бий болгох зорилгоор “Малчин” нийтийг хамарсан ажлыг зохион байгуулж, нийт 50 портер буюу 100 тн өвс хадлан тэжээл бэлтгэн малчдын цалинд 1800,0 мянган төгрөгийг олгоод байна.

“Эрүүл мэндийн довтолгоо 2014” арга хэмжээг зохион байгуулж, “Заавал хэвшүүлэх 21” дадлын ач холбогдолын талаар иргэдэд мэдээлэл өгч, тус сумын Эрүүл мэндийн төвийн зүгээс “Идэвхитэй хөлдөлгөөн алхалт” буюу 1–р дадал, “Зөв зохистой хооллолт” буюу 2-р дадлын талаар иргэдэд богино хэмжээний сургалт зохион байгуулан, эрүүл мэндийн төвөөс боловсруулсан гарын авлагыг нийт 500 айл өрхөд тарааж, 1750 иргэнд хүрч ажиллалаа.

### **4.Ерөө сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газраас худалдаа үйлчилгээний газруудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлуудад зөвлөгөө өгч арилгах арга хэмжээг авлаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас иргэдийн амьдрах таатай орчинг бүрдүүлэх, ногоон байгууламжыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан “Цэвэр орчин, ногоон төгөл” аяны хүрээнд хийгдсэн айл өрх, албан байгууллагын тохижилтын ажлын үйл ажиллагаатай танилцлаа.

Намрын ургац хураалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2014 оны 09-р сарын 20–оос 10-р сарын 05-ны өдрийг дуустал архи согтууруулах ундаа худалдан борлуулахыг тус сумын Засаг даргын захирамжаар хориглолоо.

Гар аргаар алт олборлож буй иргэдийн хууль бус үйл ажиллагааг зогсоох зорилгоор аймгийн Цагдаагийн газар, тус сумын Засаг даргын Тамгын газар, сумын Цагдаагийн хэсэг хамтран 2014 оны 09-р сарын 14-15 өдрүүдэд Могойн гол нэртэй газраас 50 гаруй гар аргаар алт олборлогчдыг албадан нүүлгэлээ.

### **6.Мандал сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газар, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран хүнсний талон авдаг 30 өрхийн иргэдэд “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдэвт лекц, хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, тус сумын Засаг даргын Тамгын газар хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд “Бизнесээ эхэл, хөгжүүл” сэдэвт төсөл бичих аргачлалаар сургалт явуулж 13 иргэнд сертификат олголоо.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, “Хараа бизнес хөгжил” төрийн бус байгууллагатай хамтран төсөл бичих арга зүй, бизнес эрхлэх арга зөвлөмжийн талаар сургалт зохион байгууллаа. Сургалтанд 15 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдаж, 1 иргэн “Хүнсний дэлгүүр”-ийн төсөл хэрэгжүүлж, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-ийн зээлд хамрагдан байнгын 3 ажлын байр бий болгож ажиллалаа.

Төв суурин газрын хүн амыг экологийн цэвэр төмс, хүнсний ногоогоор хангах зорилгоор Улаанбаатар хотын 5 цэг салбарт “Өсөх” ногоочдын бүлэг, “Өгөөж” ногоочдын бүлэг, “Уужим хараа” ХХК, “Энхтайвны” андууд бүлэг, 3 тариаланч 73 тн төмс, 125 тн хүнсний ногоо борлуулахаар худалдаалж байна.

#### **7.Сант сум:**

Тус сумын Цэвэр эрлийз малын тооллогыг аймгийн Үйлдвэр хөдөө аж ахуйн газар, сумын Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулж, сумын хэмжээнд баталгаажсан үүлдрийн Казакийн цагаан толгойт эрлийз үхэр 179 малчин өрхөд 6645 толгой үүнээс хээлтэгч 3122, хээлтүүлэгч 69, энэ жилийн төл 12568, бусад 219, баталгаажсан семминталь үүлдрийн эрлийз үхэр 1 өрхөд 38 толгой үүнээс хээлтэгч 20, хээлтүүлэгч 1, төл 14, бусад насны 3, Орхон үүлдрийн эрлийз хонь 11 өрхөд 1510 толгой үүнээс хээлтэгч 510, хээлтүүлэгч 12, төл 360, бусад 628 толгой мал тоологдлоо.

Байгалийн ургамал, ойн дагалт баялаг тэдгээрийн гаралтай түүхий эдийг бэлтгэх зөвшөөрөл бүхий Батбуудай ХХК-тай 1.000 кг Дэрэвгэр жиргэрүү ургамлын үндэс түүх гэрээг байгуулж, гэрээний хугацаанд хяналт тавин ажиллаж байна.

2014 оны 09-р сарын 22-26-ны өдрийг хүртлэх хугацаанд Улаанбаатар хотын “Дүнжингарав” худалдааны төвд зохион байгуулагдсан “Алтан намар-2014” “Эрүүл хүнс-2014” үзэсгэлэн худалдаанд тус сумын 3 иргэн 12 төрлийн хүнсний ногоогоор оролцлоо.

#### **8.Сайхан сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газар, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран “Ус, орчны эрүүл ахуй” болон CLTS ариун цэврийн байгууламжийн сургалтыг 2 үе шаттайгаар нийт 50 гаруй иргэнийг хамруулан зохион байгууллаа.

Тус сумын Засаг даргын захирамжийн дагуу сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн баасан гаригт сайхан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудыг өөрийн эзэмшил талбайгаас гадагш 50 м<sup>2</sup> газрыг цэвэрлүүлэх ажлыг зохион байгууллаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Хөтөл салбарын ДСЦТС ХК-ийн ажил үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн судалгааг иргэдээс авах зорилгоор, 217 иргэнээс судалгаа авч, нээлттэй эфирийн шууд хэлэлцүүлэг зохион байгуулан иргэдийн санал хүсэлтийг хүлээн авлаа.

Гавшгай 2-р багийн хэмжээнд Монгол Улсын хууль тогтоомж, аймаг, сумын бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангах, аж ахуйн нэгж, иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлэх, багийн Засаг даргын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд бүхий л талын дэмжлэг туслалцаа үзүүлэх, багийн үйл ажиллагааг иргэдэд таниулах зорилгоор 2014 оны 09-р сарын 13-ны өдөр “Эрхзүйн мэдээллийг иргэн бүрт-Баг сурталчлах өдөрлөг”-ийг Овоот хороололд зохион байгууллаа.

#### **9.Сүхбаатар сум:**

Тайлант сард тус сумын Засаг даргын Тамгын газраас зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн дунд БЗХӨ–ХДХВ, ДОХ өвчнөөс урьдчилан сэргийлэх, үе тэнгийн сургагч бэлтгэх сургалтыг 3 удаа 2014 оны 9-р сарын 10, 18, 24-ний өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтанд нийт давхардсан тоогоор 40 эмэгтэйг хамрууллаа.

Тайлант хугацаанд тус сумын “Гурван мэргэд” хүнсний захын гадна талбайд ил задгай гар дээрээс худалдаа наймаа хийж буй иргэдэд хяналт шалгалт хийж ил задгай самар зарж байгаа 4 иргэн /бүгд гарал үүслийн бичиггүй, шинжилгээний бичиггүй/, ил задгай хүнсний ногоо зарж байгаа 5 иргэнд илэрсэн зөрчил дутагдалыг газар дээр нь арилгуулан мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажиллалаа.

2014 оны 09-р сарын 03-нд иргэдийн санал хүсэлт гомдлын дагуу тус сумын Засаг даргын Тамгын газраас Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих зорилгоор хэсгийн цагдаатай хамтран 2-р багийн нутаг дэвсгэрт байрлах хүнсний дэлгүүрүүдэд хяналт шалгалт хийлээ.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, тус сумын Засаг даргын Тамгын газар, “Хараа бизнес хөгжил” ТББ-тай хамтран “Бизнес төсөл боловсруулах” сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулан зохион байгуулж, иргэдийг чадамжийн гэрчилгээтэй төгсгөлөө.

#### **10.Хушаат сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газраас “Архи тамхигүй сум” аяны хүрээнд 9-12 сард 3 сарын хугацаатай “Архи, тамхигүй хамт олон” болзолт уралдааныг төр, төсвийн байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дунд зарлалаа.

Тус сумын Засаг даргын А/136 тоот захирамжаар Хушаат суманд 10-р сарын 25 хүртэл намрын ажил, өвөлжилтийн бэлтгэл ажлын үеэр орой 19 цагаас өглөөний 07 цаг хүртэл архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, үйлчлэхийг хориглож, төр төсвийн байгууллагууд ээлжлэн хариуцлагатай жижүүр томилон ажиллуулж байна.

Улаанбаатар хотод зохиогдож буй “Намрын ногоон өдрүүд-2014” арга хэмжээнд тус сумаас 2 аж ахуйн нэгж, 4 иргэн оролцож төмс, луувангийн 6 шинэ сортыг сурталчилж 16 тн төмс, хүнсний ногоо борлууллаа.

#### **11.Хүдэр сум:**

Цаг агаарын тааламжгүй нөхцөл байдлаас шалтгаалан тус сумын тарианы болц оройтон ургац хураалт хүндэрч болзошгүй байдлыг ургац хураалтын комиссын хүрээнд хэлэлцэн аж ахуйн нэгжүүдийн ажлыг эрчимжүүлэх, аймгийн ургацын штабтай байнгын холбоотой байж, өдөр тумын мэдээг өгч байх, орон нутгийн хэмжээнд авах арга хэмжээг цаг алдалгүй шуурхай шийдвэрлэж ажиллах чиглэл гаргалаа.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс тус сумын ерөнхий боловсролын сургуулийн багш сурагчдын дунд “Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэгдэж буй гэмт хэрэг түүний шалтгаан нөхцөл цаашид авах арга хэмжээ” сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 93 сурагч, 11 багш хамрагдлаа.

Тус сумын эрүүл мэндийн төвийг Эрдэмтэн доктор Ж.Шагжийн нэрэмжит болгох ёслолын үйл ажиллагааг зохион байгуулж, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал н.Нямхүү, аймгийн Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга н.Даваасүрэн, эм зүйч доктор Амбага, сумын удирдлагууд, Шагжийн ар гэр үр хүүхэд зочид төлөөлөгчид оролцлоо.

#### **12.Орхонтуул сум:**

Тус сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг суманд үйл ажиллагаа явуулж буй эргэлтийн эмийн сангуудад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, зөрчил бүхий бүтээгдэхүүн илрээгүй байна.

9-р сарын байдлаар Рашаант тосгоны Эрүүл мэндийн төвд нийт 14 хүн хэвтэн эмчлүүлж, 111 ор хоног ашиглалаа. Нийт 305 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 57, амбулаторийн үзлэг 124, идэвхтэй хяналтаар 26, гэрийн эргэлт 47, гэрийн дуудлага 51 байна. Үүнээс алсын дуудлага 7 байна.

Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн зөв хэвшил төлөвшүүлэх зорилгоор тус сумын эрүүл мэндийн төвийн эмч сувилагч нар айл өрхөөр 5 чиглэлд 102 айл өрхийн 389 хүн амд сургалт сурталчилгааг хийж, “Заавал хэвшүүлэх 21 дадал” номыг тараагаад байна.

Байгаль орчны яамны Ан агнуурын албанаас тус суманд 2014 оны 08-р сарын 27-28-ны өдөр ажиллаж, ан агнуурын бүс тогтоон, ойн анги байгуулах газруудыг тогтоох санал авлаа.

### **13.Орхон сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газар нь 2014 оны 09-р сарын 04-ний өдөр иргэдийн дунд “Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК-ийн үйл ажиллагааны талаарх иргэдийн санал, нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Тус сумын хэмжээнд шилмэл, эрлийз тооллогоор малын Орхон үүлдрийн хонь хээлтэгч 2036, төл 1271, бусад 1262, бүгд 4572 толгой, Сэлэнгэ монголын эрлийз үхэр хээлтэгч 1530, бүгд 4751 толгой үхэр, Орхон монголын эрлийз хонь 3595 толгой бүгд 12918 толгой мал бүртгэгдлээ.

Ургац хураалтын мэдээгээр нийт 12471 га талбайд үр тариа тариалснаас улаан буудай 6246 га талбайг ангилан, 4034 га хураан авснаас 5304 тн ургац, рапс 200 га талбай хурааснаас 200 тн ургац, төмс 300 га талбайд тариалснаас 248 га талбайг хурааж 3720 тн, хүнсний ногоо 111 га талбайд тариалалт хийж 83 га хурааж 1165 тн ургац хураагаад байна.

Тайлант хугацаанд Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй “Ажлын гараа” төслийн “Хадлан бэлтгэл”-ийн ажилд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 18-35 насны 5 залууг 1 сарын хугацаанд ажиллуулан 1,0 сая төгрөгийн урамшуулал олголоо.

### **14.Цагааннуур сум:**

2014 оны 09-р сарын 05-ны өдөр Цагааннуур суманд аймгийн нийт сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга болон нарийн бичгийн дарга нарын сургалт, семинарыг зохион байгууллаа.

2014 оны 09-р сарын 08-ны өдөр тус сумын Засаг даргын Тамгын газраас “Дархан Сэлэнгийн Цахилгаан түгээх сүлжээ” ХК-тай хамтран “Танд хэлэх санал гомдол байна уу?” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэгийг зохион байгуулж, иргэдийн санал сэтгэгдлийг хүлээн авч, нийт 100 гаруй иргэд хамрууллаа.

2014 оны 09-р сарын 21-нд сумын Засаг даргын Тамгын газраас “Сүүн цацал арга” хэмжээг ахмадуудын дунд зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр “Нинж Долбин” хийд дээр ном хурах, Ламхайн овоо дээр өргөл өргөх зэрэг үйл ажиллагаа явагдлаа.

Намрын ургац хураалтын ажил эхэлсэнтэй холбогдуулан цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг 7 хоног бүр сумын газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг иргэд аж ахуй нэгжүүдэд мэдээллэж байна.

### **15.Түшиг сум:**

Тус сумын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийн сумын Засаг даргын 2014 оны А/88 тоот захирамжаар томилон ажиллуулж байна. Ажлын хэсэг халаалтын зуух, цахилгаан шугам, тоног төхөөрөмжүүдийн найдвартай ажиллагааг ханган, гүйцэтгэлд хяналт тавьж, 2014 онд хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэн, мал сүргийн тарилга туулгалтыг технологит хугацаанд багтаан дуусгаж, хадлан тэжээлийн бэлтгэл, төмс, хүнсний ногооны хураалтанд анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас 2014-2015 оны өвөл Улаан-овоогийн нүүрсний уурхайгаас нийт 1170 тн нүүрс худалдаан авах гэрээ байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын хамт олон 2014 оны 08-р сарын 25-27-ны өдрүүдэд Түшиг суманд ирж, тус сумын Засаг даргын Тамгын газартай харилцан туршлага солицох арга хэмжээг зохион байгууллаа.

Жил бүр уламжлал болон зохион байгуулж буй уяачдын баярыг тус сумын Засаг даргын Тамгын газар, “Түшиг ажнай” уяачдын холбоо хамтран зохион байгууллаа.

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**